БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 23 өдөр Дугаар А/227 Улаанбаатар хот

"Иргэний андгай өргөх ёслол"-ын арга хэмжээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Нийслэлийн өдөр Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 387 жилийн ойн баярыг тохиолдуулан Монгол Улсын "Иргэний андгай өргөх ёслол"-ын арга хэмжээнд дүүргийн иргэний цахим үнэмлэх шинээр авах 16 нас хүрсэн иргэдийг 2026 оны 10 дугаар сарын 28-ны өдөр оролцуулахыг Улсын бүртгэлийн хэлтэс (М.Уранцэцэг)-т үүрэг болгосугай.

2."Иргэний андгай өргөх ёслол"-ын үйл ажиллагаа зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар, иргэний цахим үнэмлэх шинээр авах сурагчдын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулагдах 2,542,700 (хоёр сая таван зуун дөчин хоёр мянга долоон зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Х.ЦОГЦЭЦЭГ

AJIL\2026 он ажил\захирамж

1226106658

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дүгээр сарын 23-ны өдрийн
А/227 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

“ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Эх орны ирээдүйн эзэн болох 16 нас хүрсэн сурагчдын төлөөлөлд Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний цахим үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулсанаар тэднийг эх орон түүх соёлоороо бахархах, иргэний үүргээ биелүүлэх ухамсарт иргэн болж төлөвшихөд хувь нэмэр оруулахад оршино.

Хамрах хүрээ:

16 нас хүрч шинээр иргэний үнэмлэхээ гардан авах сурагчид оролцоно.

Зохион байгуулах газар:

Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс

Хугацаа, зохион байгуулагдах газар:

2026 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 10.00 цагт дүүргийн ЗДТГазрын “Хурлын танхим”-д зохион байгуулагдана.

Тавигдах шаардлага:

Оролцох сурагчдын төлөөлөл ёслолын хувцастай байна. /сурагчийн форм/

Зохион байгуулах үйл ажиллагаа:

16 нас хүрсэн сурагчдад Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулан Монгол улсын “Иргэний андгай” өргөнө. Дүүргийн ИТХ-ын дарга, засаг дарга зэрэг удирдлагуудтай дурсгалын зураг авахуулна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дүгээр сарын 23 -ны өдрийн
А/227 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“ИРГЭНИЙ АНДГАЙ” ӨРГӨХ ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
3	Ном	ш	52	20000	1,040,000
4	Бал	ш	52	2500	130,000
5	Дэвтэр	ш	52	15000	780,000
6	Дурсгалын зураг	ш	52	5000	260,000
7	Тавгийн чихэр	кг	5	15000	75,000
8	Ундаа	ш	60	2500	150,000
9	Бензин зардал	Л	30л	3590	107,700
Нийт					2,542,700